# УЛААНБААТАР
## хотын Ардын Депутатуудын хурлын Гүйцэтгэх Захиргааны
# ТОГТООЛ

Улаанбаатар хот

1974 оны I дүгээр
сарын I9 ний өдөр

Дугаар 8

АВТО ГРАЖ БАЙГУУЛАХ ТУХАЙ

Хотын АДХ-ын Гүйцэтгэх захиргааны харъяа газар, хэлтсүүдийн дуудлагын ба дежурын машинууд нь төвлөрсөн удирдлага диспетчерийн хяналтгүй тус тусдаа байгаагаас гүйлтийн ба шатахууны нормыг хэтрүүлэх, авор осол гаргах, хувийн хэрэгцээнд ашиглах запас сэлбэггүй удаан хугацаагаар зогсох зэрэг зөрчлүүд гарч байгаа тул МАХН-ын Төв Хороо, БНМАУ-ын Сайд нарын Зөвлөлийн I959 оны 335/28I, I966 оны 242/342-р тогтоолыг удирдлага болгон Улаанбаатар хотын Ардын Депутатуудын Хурлын Гүйцэтгэх Захиргаанаас ТОГТООХ НЬ:

I.Хотын АДХ-ын Гүйцэтгэх Захиргааны шууд харъяа газар хэлтсүүдийн дежур, дуудлага үйлчилгээний авто машиныг нэгтгэн Сангийн Яамнаас баталсан төсвийн дагуу хотын АДХ-ын Гүйцэтгэх Захиргааны харъяанд хөнгөн тэрэгний граж байгуулсугай.
/Нэгтгэх машины жагсаалтыг хавсаргав./

2.Авто гражид ДААЛГАХ НЬ:

✓ а/ жолооч нарын ажлын хариуцлага, сахилга бат, техникийн мэдлэг, соёл хүмүүжлийг байнга дээшлүүлэх ажлыг төлөвлөгөөтэй явуулан тогтмол шалгалт авч байсугай.

✓ б/ машин бүр дээр өдөр тутмын ашиглалт, засвар үйлчилгээний анхан шатны бүртгэлийг нарийн хөтлөж сар бүрийн эцэст тайлан гаргаж ажилчдын зөвлөлгөөнөөр хэлэлцэн дүгнэж байх;

✓ в/ авто машины эд анги, түлхүүр багажийг эвдсэн буюу үрэгдүүлсэн байвал тухай бүр акт тогтоож буруутай жолоочоор нь жинхэнэ шинэ сэлбэгийн үнээр төлүүлж байсугай.

г/ Авто машин нь завсартай байх үед уг машины жолоочийг засвар дээр нь ажиллуулан засварчны цалин олгох;

д/ зохих зөвшөөрөлтэйгээр ажилчин албан хаагчид, жолооч нараас авто машиныг хувийн ажилд хэрэглэвэл км бүрт I төгрөг 50 мөнгөөр бодож хөлсийг хураан авах;

е/ авто машины гүйлт ба шатахууны нормыг хэтрүүлэхгүйн тулд /албаны ба амины гэсэн/ тусгай талон хэвлүүлж 8-р сарын I-нээс эхлэн хэрэглэсүгэй.

3.Авто гражийн өдөр тутмын ажилд хяналт тавьж, тодорхой удирдлагаар хангаж байхыг хотын АДХ-ын Гүйцэтгэх захиргааны Аж ахуйн хэлтэс /н.Ц.Алтангэрэл/-д үүрэг болгосугай.

Б.Н.М.А.У Гүйцэтгэх Захиргаа

УЛААНБААТАР ХОТЫН АДХ-ЫН ГҮЙЦЭТГЭХ
ЗАХИРГААНЫ ДАРГА С. [signature] С.БАЛБАР

УЛААНБААТАР ХОТЫН АДХ-ЫН ГҮЙЦЭТГЭХ
ЗАХИРГААНЫ ХАРИУЦЛАГАТАЙ НАРИЙН
БИЧГИЙН ДАРГА [signature] Д.ДАМДИНСҮРЭН

Улаанбаатар хотын АДХ-ын Гүйцэтгэх
Захиргааны 1972 оны 8-р тогтоолоор
батлав.

## ХОТЫН АДХ-ЫН ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРГААНЫ ХӨНГӨН ТЭРЭГНИЙ ГРАЖИД НЭГТГЭХ СУУДЛЫН АВТО МАШИНЫ ЖАГСААЛТ

| Асуулт / Байгууллагын нэр | Суудлын авто машин: Марк | Суудлын авто машин: Улсын дугаар | Үйлчилгээний зориулалт | Суудлын авто машин хэрэглэж байгаа: Албан тушаал | Суудлын авто машин хэрэглэж байгаа: Олгогдсон эрхийн дугаар, он, сар |
|---|---|---|---|---|---|
| 1. УБ хотын АДХ-ын Гүйцэтгэх Захиргаа | ГАЗ-24 | УБ 89-08 | Албан тушаалын машин | Хотын дарга | Сайд нарын Зөвлөлийн 1969-12-19 428-р тогтоол |
| 2. -"- | ГАЗ-69 | УБ 01-69 | -"- | -"- | СнЗ-ийн 1969-12-19 418-р тогтоол |
| 3. -"- | М-21 | УБ 89-95 | Дуудлага | 1-р орлогч дарга | СнЗ-ийн 1969 оны 418-р тогтоол |
| 4. -"- | ГАЗ-24 | 20-25 | -"- | Орлогч дарга | СнЗ-ийн 1969-12-19 418-р тогтоол |
| 5. -"- | М-21 | УБ 54-77 | -"- | -"- | -"- |
| 6. -"- | М-21 | УБ 01-92 | -"- | -"- | СнЗ-ийн 1972 оны 431-р тогтоол |
| 7. -"- | ГАЗ-69 | УБ 72-43 | -"- | -"- | СнЗ-ийн 1969 оны 418-р тогтоол |
| 8. -"- | М-21 | УБ 80-77 | -"- | Хариуцлагатай нарийн бичгийн дарга | -"- |
| 9. -"- | МОС-408 | АА 00-03 | -"- | Хотын Ерөнхий Архитектор | Улсын Төлөвлөгөөний комиссын 1970 оны 267-р тогтоол |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| I0.-"- | М-2I | УБ 37-80 | -"- | АБ-ын хэлтсийн дарга | СнЗ-ийн I972 оны I26-р захирамж |
| II.-"- | М-2I | УБ 02-84 | -"- | Хотын биеийн тамирын зөвлөлийн дарга | БНМАУ-ын СнЗ-ийн I965 оны 36I-р тогтоол |
| I2.-"- | УАЗ-469 | УБ 80-I7 | -"- | ХАА-н хэлтсийн дарга | СнЗ-ийн I972 оны 232-р тогтоол |
| I3. УБ хотын А АДХГЗ-ны Захын контор хотын санхүүгийн дарга | ГАЗ-69 | УБ 97-54 | дуудлага | Санхүүгийн хэлтсийн дарга | СнЗ-ийн I97I оны I06-р захирамж |
| I4.УБ хотын АДХ-ын Гүйцэтгэх Захиргааны Иргэний хамгаалалт | ГАЗ-69 | УБ 4I-80 | -"- | Хотын иргэний хамгаалалтын штабын дарга | СнЗ-ийн I969 оны 93-р тогтоол |
| I5.УБ хотын АДХГ Захиргааны Захиалагчийн товчоо | ГАЗ-69 | УБ 74-44 | -"- | Захиалагчийн товчооны дарга | СнЗ-ийн I969 оны 4I8-р тогтоол |
| I6.УБ хотын АДХГ Захиргааны жижүүр | ГАЗ-69 | УБ 06-I8 | Жижүүр | Жижүүр | -"- |
| I7.-"- | УАЗ-450 | УБ 23-97 | -"- | -"- | -"- |
| I8.УБ хотын Мал эмнэлгийн тасаг | ГАЗ-69 | УБ 78-74 | Түргэн тусламжийн дуудлага | Дарга, эмч нар | -"- |
| I9.-"- | ГАЗ-69 Б | УБ 68-36 | Халдвартын дуудлагын | Мал эмнэлэг халдвар шинжилгээ | -"- |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| 20.УБ хотын Иргэдийг үйлчлэх товчоо | ГАЗ-69Б | УБ 78-73 | -"- | Иргэдийг үйлчлэх товчооны дарга | -"- |
| 21.УБ хотын АДХГЗ-ны Хот тохижуулах газар | М-21 | УБ 14-60 | -"- | Хот тохижуулах газрын дарга | -"- |
| 22.-"- | ГАЗ-69А | УБ 95-91 | Жижүүр | Жижүүр | -"- |
| 23.-"- | ГАЗ-51 | УБ 86-78 | Үйлчилгээ | үйлчилгээ | -"- |
| 24.-"- | ГАЗ-51 | УБ 49-90 | үйлчилгээ | -"- | -"- |
| 25.УБ хотын АДХГЗ-ны Сүхбаатарын район | М-21 | УБ 24-66 | дуудлагын | Сүхбаатарын районы дарга | -"- |
| 26.УБ хотын АДХГЗ-ны Октябрийн район | М-21 | УБ 62-58 | -"- | Октябрийн районы дарга | -"- |
| 27.УБ хотын АДХГЗ-ны Найрамдлын район | М-21 | УБ 50-95 | -"- | Найрамдлын районы дарга | -"- |
| 28.УБ хотын АДХГЗ-ны Ажилчны район | МОС-408 | УБ 82-48 | дуудлагын | Ажилчны районы дарга | -"- |
| 29.УБ хотын шүүх | М-21 | УБ 03-93 | -"- | Хотын шүүхийн дарга | СнЗ-ийн 1959 оны 385/281-р тогтоол |
| 30.УБ хотын шүүх | ЖУК | УБ 63-64 | жижүүр | жижүүр | УТК 1969 оны 174-р тогтоол |
| 31.УБ хотын шүүхийн | ГАЗ-51 | УБ 93-08 | үйлчилгээ | захиргаа аж ахуйн үйлчилгээнд | СнЗ-ийн 1960 оны 8-р тогтоол |
| 32.УБ хотын Өндөр настан | ЗИЛ-130 | УБ 13-70 | Дотоод тээвэрт | Өндөр настны | СнЗ-ийн 1969 оны 418-р тогтоол |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| 33. -"- | ГАЗ-69Б | УБ-97-77 | дуудлага | Өндөр настны зөвлөлийн дарга | -"- |
| 34. Хотын шүүх | ГАЗ-69 | | районы шүүхийн хэрэгцээнд | | БНМАУ-ын СнЗ-ийн 1972 оны 228-р тогтоолоор олгогдсон |
| 35. -"- | ГАЗ-69 | | -"- | | -"- |
| 36. Хотын мал эмнэлгийн лабораторид | ГАЗ-69 | | | | БНМАУ-ын СнЗ-ийн 1972 оны 228-р тогтоолоор олгогдсон |
| 37. -"- | ГАЗ-69 | | | | -"- |
| 38. Хотын Прокурор | М-21 | УБ 41-19 | дуудлагын | Хотын Прокурорын дарга | |
| 39. -"- | ГАЗ-69 | УБ 23-19 | үйлчилгээ | Тогтоол гүйцэтгэгч | |
| 40. -"- | УАЗ-451 | УБ 64-67 | жижүүр | нар | |
| 41. -"- | ГАЗ-69 | | | | БНМАУ-ын СнЗ-ийн 1972 оны 228-р тогтоолоор олгогдсон |
| 42. -"- | ГАЗ-69 | | | | -"- |

УЛААНБААТАР ХОТЫН АДХ-ЫН ГҮЙЦЭТГЭХ

З А Х И Р Г А А